

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 01 сарын 19-ны өдөр

Дугаар...

БА-094/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянгол дүүргийн 29 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 18 (арван найм) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 112 (нэг зуун арван хоёр) айлын орон сууцны зориулалттай барилга, зорьтой 2 давхар 2 блок, 12 (арван хоёр) автомашины дулаан зогсоолтой үйлчилгээний зориулалттай барилга нийт 3 блок барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

**Хоёр. Ерөнхий мэдээлэл**

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/06/19 огноо, БАЗГ2024/0184 №0000377 дугаар;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: МЛ-АЗ-22/002;

2.3. Захиалагч: Эрин Интернэшнл ХХК оноосон нэр, 9019015133 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2715678 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29 дүгээр хороо, өөрийн байр, 7000-1709 холбоо барих утас, [info@erininternational.mn](mailto:info@erininternational.mn) цахим хаяг;

2.4. Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч: Сүрлэг Уул ХХК оноосон нэр, 9011084002 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5113229 регистрийн дугаар, БУ12-938/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо, 7 дугаар хороолол, Хийморь оффис 9 давхар 907 тоот, 99119254, 91116353, 91117389 холбоо барих утас,

2.5. Барилгын туслан гүйцэтгэгч байгууллага: Духант хүлэг ХХК оноосон нэр, 9011757017 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 4134427 регистрийн дугаар, БУ38-1253/17 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Хууль сахиулах 1 хотхон 49Б байр, 1 давхар, 88077089, 77770083 холбоо барих утас,

Монхайц Партнер ХХК оноосон нэр, 9011473143 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5841887 регистрийн дугаар, БУ12-251/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Намьяанжугийн гудамж 14 А байр, 103 тоот, 88002451, 91179043 холбоо барих утас,

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Хууль сахиулах 1 хотхон 49Б байр, 1 давхар, 88077089, 77770083 холбоо барих утас,  
Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

Олл универсал ХХК оноосон нэр, 9011719037 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6263585 регистрийн дугаар, ӨБ18-590/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 7 дугаар хороо, Жаргалантын 2, 66, тоот, 99088284, 99060918 холбоо барих утас,

Гал импекс ХХК оноосон нэр, 9011487016 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5844096 регистрийн дугаар, БУ17-721/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо, үйлдвэрчний эвлэлийн гудамж, 150/1 тоот, 94990101, 11463614 холбоо барих утас,

Титан Грид ХХК оноосон нэр, 9011298148 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5499658 регистрийн дугаар, ЗТ-157/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, Гутал ХК-ийн байр 307 тоот, 9111-8731 холбоо барих утас,

Кью эйл ти трейд ХХК оноосон нэр, 9011369121 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5637465 регистрийн дугаар, БУ12-271/19 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, Замчдын гудамж, Эй энд Эйч центр, 5 давхар, 501 тоот 95945115 холбоо барих утас;

ЖМДМ ХХК оноосон нэр, 9011355096 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5609488 регистрийн дугаар, 1066/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, 6 дугаар хороолол, 5-44 тоот, 99992316 холбоо барих утас;

Зегийч өргөө констракшн ХХК оноосон нэр, 9011813025 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6497977 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29 дүгээр хороо, 53/7-128, 95767650, 80117650 холбоо барих утас,


2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Максимум Лайн ХХК оноосон нэр, 9011321046 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5538246 регистрийн дугаар, ЗТ16-983/23 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Их сургуулийн гудамж 34-101 тоот, 99684110, 99908616 холбоо барих утас, [maxmmlne11@gmail.com](mailto:maxmmlne11@gmail.com) цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Эрин барилга ХХК оноосон нэр, 9011017142 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2722615 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29 дүгээр хороо Эрин Интернэшнл ХХК-ийн байр, 206 тоот, 77221788, 99101947 холбоо барих утас,

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:



- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 18 (арван найм) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 112 (нэг зуун арван хоёр) айлын орон сууцны зориулалттай барилга, зорьтой 2 давхар 2 блок, 12 (арван хоёр) автомашины дулаан зогсоолтой үйлчилгээний зориулалттай барилга нийт 3 блок барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.


3.4. Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 18 (арван найм) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 112 (нэг зуун арван хоёр) айлын орон сууцны зориулалттай барилга, зорьтой 2 давхар 2 блок, 12 (арван хоёр) автомашины дулаан зогсоолтой үйлчилгээний зориулалттай барилга нийт 3 блок барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянгол дүүргийн 29 дүгээр хороо, Эрин Интернэшнл ХХК-ийн захиалгатай, зорьтой 16 давхар 1 блок, 18 (арван найм) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 112 (нэг зуун арван хоёр) айлын орон сууцны барилга, зорьтой 2 давхар 2 блок, 12 (арван хоёр) автомашины дулаан зогсоолтой үйлчилгээний барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:  
Эрин-Интернэшнл ХХК-ийн дэд захирал



(Б.Даваасүрэн)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 29 ДҮГЭЭР ХОРОО, ЭРИН ИНТЕРНЭШНЛ ХХК-ИЙН  
ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 2 ДАВХАР 2 БЛОК, 12 (АРВАН ХОЁР)  
АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА, ЗООРЬТОЙ  
16 ДАВХАР 1 БЛОК, 18 (АРВАН НАЙМ) АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ,  
ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 112 (НЭГ ЗУУН АРВАН ХОЁР) АЙЛЫН ОРОН СУУЦНЫ  
ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ 3 БЛОК БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 29 дүгээр хороо, Эрин интернэшнл ХХК-ийн захиалгатай, зорьтой 2 давхар 2 блок, 12 (арван хоёр) автомашины дулаан зогсоолтой үйлчилгээний барилга, зорьтой 16 давхар 1 блок, 18 (арван найм) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 112 (нэг зуун арван хоёр) айлын орон сууцны зориулалттай нийт 3 блок барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 3-р давхарт 37 тоотод 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр 13:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 14:30 цагт дуусав.

Хяналт шалгалтын  
Барилга байгууламжийг ашиглалтад  
оруулах комисс

Хуралд:

1. Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтэсийн дарга О.Оджаргал
2. Хяналт шалгалтын газрын барилгын стандарт,  
аюулгүй байдлын хяналтын хэлтэс,  
Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Ж.Жүгдэрмаа
3. Хяналт шалгалтын газрын  
Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс,  
Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Э.Цогзолмаа
4. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК,  
Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн инженер М.Мөнхтөр
5. Ус сувгийн удирдах газрын,  
Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер Г.Үүрийнгэгээ
6. Цахилгаан түгээх сүлжээ,  
Эрин Энержи Консалтинг ХХК-ийн цахилгааны инженер Д.Дэлгэрхи
7. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК,  
Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Дагвадорж
8. Онцгой байдлын ерөнхий газар,  
Гал түймэртэй тэмцэх газрын,  
Зураг хяналтын тасаг, Дэд хурандаа М.Батсайхан
9. Барилга хөгжлийн төв  
Норм, нормативын хэлтэсийн мэргэжилтэн О.Ундрах
10. Үндэсний төв архив, Зураг төслийн  
Баримтын архивч Н.Өлзийжаргал
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах  
байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн  
үндэсний холбоо, хүртээмжийн үнэлгээний ажилтан Д.Ганбат

12. Ашиглалт хариуцах байгууллага, Эрин барилга ХХК-ийн гүйцэтгэх захирал	Ж.Ууганбаяр
13. Зураг төсөл зохиогч, Максимум Лайн ХХК-ийн гүйцэтгэх захирал	Б.Жавхлантөгс
14. Барилгын ажлын гүйцэтгэгч, Сүрлэг Уул ХХК-ийн дэд захирал	Б.Лхагвасүрэн
15. Захиалагч байгууллага, Эрин-Интернэшнл ХХК-ийн Дэд захирал	Б.Даваасүрэн

#### ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан– 15

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянгол дүүргийн 29 дүгээр хороо, Эрин интернэшнл ХХК-ийн захиалгатай, зорьтой 2 давхар 2 блок, 12 (арван хоёр) автомашины дулаан зогсоолтой үйлчилгээний барилга, зорьтой 16 давхар 1 блок, 18 (арван найм) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 112 (нэг зуун арван хоёр) айлын орон сууцны зориулалттай нийт 3 блок барилга байгууламжийг ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

#### СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилга техникийн хяналтын улсын байцаагч **Ж.Жүгдэрмаа:**

- Давхар бүрийн бетон арматурын лабораторийн шинжилгээний дүнг үзүүлэх зохиогчийн дүгнэлтийг дахин хянуулах.
- А В блокийн дээвэр 3-р давхрын айлын гуна хана цонхны доод түвшинд байгаа зураг төсөл угсралтын үеийн фото зураг үзэх.
- А В блокийн ханын хаалт хамгаалалт /шалнаас тааз хүртэл/ ашиглалтын аюулгүй байдлыг хянуулж, зоорийн таазны заслыг гүйцээх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалт оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа:**

- Давхар бүрийн дулааны коллекторыг цэвэрлэж, хаягжуулах, зэврэлтээс хамгаалах будаг түрхэх
- Айл өрхийн коллекторыг цэвэрлэх
- Халаах хэрэгслүүд дээр термостат суурилуулах
- Зоорийн давхарын АС-ийг бүрэн дуусгах
- 1 ба 2 давхарын үйлчилгээний АС-ийг бүрэн угсарч дуусгах

- Гадна дулаан хангамжийн системийг угсарсан, сорилтоор шалгасан актыг бүрэн баталгаажуулах
- Холигч насосыг узелийн шугам хоолойг дахин цэвэрлэх, хаягжуулах
- ҮДДТ-ийн шугам угсралтын ил далд акт хянуулах

Гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн инженер **М.Мөнхтөр:**

- 101 блок орон сууцны холигч узелийн хаягжуулалт хийх, дулаалга, хог шороог дахин цэвэрлэх.
- Гадна дулааны худагт шат тавцанг стандартын дагуу хийх уртасгах дулаалга хог шороог цэвэрлэх. /тунель доторхи/

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай.

Ус сувгийн удирдах газар, хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер **Г.Үүрийнгэгээ:**

- Нөөцийн савны угааж халдваргүйжүүлэлт хийсэн Ус Био инженеринг ХХК-ийн тусгай зөвшөөрөл шалгуулах
- Угаалга халдваргүйжүүлэлтийн актыг тамга, тэмдгээр баталгаажуулах
- Нөөцийн савнаас болон дотор айлын ус авах хэрэгслээс харьцуулсан сорьц өгч дүгнэлтийг шалгуулах/MNS 0900:2018 стандарт хангасан байх/
- 101, А, В блокын бохир усны нэг гаргалгааг хассан учраас зохиогчийн тайлбар дүгнэлт, ашиглалт хариуцсан байгууллагаас баталж бичиг ирүүлэх
- зоорийн давхарын буюу /Дулаан зогсоолын хэсэгт ус зайлуулах суваг-трап зурагт тусгагдсаны дагуу угсрах /трапны ус зайлуулах, насос суурилуулах /Q=1 м.куб цаг, P=0,75 кв.т, и=220в/
- Гүйцэтгэлийн зураг, гадна цэвэр усны шугамын акт шалгуулах
- Бохир усны ил далд ажлын актыг хангагч байгууллагаар баталгаажуулах
- УСУГ-тай хийсэн гэрээ шалгуулах
- 101, А, Б блокийн хойгуур байршилтай 1200 мм-ийн бохир усны төв шугамаас барилгын баруун хойд хэсэгт хэмжилт хийлгэж, албан бичгээр ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр барилгыг байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Цахилгаан түгээх сүлжээ, Эрин-Энержи Консалтинг ХХК-ийн цахилгааны инженер **Д.Дэлгэрхи:**

- Гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах хүсэлтэй байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Ц.Дагвадорж:**

- Нэвтрэх системийг ажиллуулах
- Гадна холбооны угсралтын ажлыг МХС ТӨХК-нд актаар хүлээлгэн өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газрын, Гал түймэртэй тэмцэх газрын, Зураг хяналтын тасгийн ахлах байцаагч, дэд хурандаа **М.Батсайхан:**

- Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу барилга руу орох гарах гарцыг нээх хамгаалалтын хашааг авах.
- Бүх давхрын шатыг тусгаарлах галд тэсвэртэй хаалганд өөрөө хаагч тоноглол хийх
- Цахилгааны ерөнхий шитний өрөөнд галын дохиолол мэдээлэгч хийх бие даасан гал унтраах автомат төхөөрөмж суурилуулах
- А Б блокийн 2-р давхарт ГК гал унтраах цэгийг зураг төслийн дагуу хийх
- Гүйцэтгэлийн зураг төсөл хянуулах
- 1-р давхрын угтах хэсгийн /лобби/ дотор заслын хавтан материалын гал тэсвэржилтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт үзүүлэх
- Шатны хонгилд даралттай агаар өгөх системийг хэвийн болгох
- Зоорийн давхрын автомашины зогсоолын трап хийгдээгүй байгааг хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай.

Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтсийн мэргэжилтэн **О.Ундрах:**

- Шатны хонгилын цонхны нээлхийд хязгаарлагч хийх.
- Блок хоорондын температурын заадастай хэсгийн хана, шал таазны заслыг тусд нь хийж зориулалтын ам дарагч хэрэглэх.
- Шатны хонгилын 1-р давхрын хаалгыг гадагшаа гол орц руу зөв онгойлттой болгох.
- В1 давхард 101, 102, 111, 112, 127, 128, 129, 130 дугаартай зогсоолуудын яндангийн утаа сорох системийг угсрах.
- Зм-с дээш өндөртэй өрлөгийн хучилтэнд хийгдсэн бэхэлгээ хийсэн акт фото зураг үзүүлэх.
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж төлөх.

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай.

Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивч **Н.Өлзийжаргал:**

- Блок тус бүрээр баримтыг нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдүүлж хуудас дугаарлаж дотоод товъёог үйлдэх
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийг гүйцэтгэгч байгууллагаар баталгаажуулах.
- Баримт бичгийн эх хувийг хүлээлгэн өгөх хуулбар хувийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Д.Ганбат:**

- В1 давхрын налуу замын уналт болон хаалганы босго дээр дараагийн блок дээр анхаарах.
- Үйлчилгээний 1,2-р давхарт нэг ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд стандартын дагуу тоноглох.

- Цахилгаан шатыг монгол хэлээр ярьдаг болгох мөн давхар бүрт брайль тэмдэглэгээ хийх.
- Шатны түвшин зөрүүтэй газар болон давхар шат дээр анхааруулах наалт наах болон тэмдэглэгээ хийх.
- Айл бүрийн хаалганд брайль тэмдэглэгээ бүхий тоо хийх.
- Фото зургаар баталгаажуулж өгөх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах хүсэлтэй байна.

Ашиглалт хариуцах байгууллага, Эрин барилга ХХК-ийн гүйцэтгэх захирал **Ж.Ууганбаяр:**

- Шугам хоолой, тоног төхөөрөмж, түүний хэвийн ажиллагаа, өнгө үзэмж, хаягжуулалт хийх

Комиссын үүгээр даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Зураг төсөл зохиогч, Максимум Лайн ХХК-ийн гүйцэтгэх захирал **Б.Жавхлантагс:**

- Үйлчилгээний ариун цэврийн өрөөний халаах хэрэгсэл хийх.
- Зоорийн давхарт өндрийн хязгаарын тэмдэглэгээ хийх
- Гонхнуудад халуун хөшиг суурилуулах
- Айлуудыг чөлөөтэй орох гарах нөхцөлөөр хангах, 102 103 блокоос хаалт хашлага хийх түр хашаа хийх, 101 А В блокийн оршин суугч ажилчид үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах.

Комиссын гишүүдийн биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч, Сүрлэг Уул ХХК-ийн дэд захирал **Б.Лхагвасүрэн:**

- Байнгын ашиглалтад оруулах саналтай.

Захиалагч байгууллага, Эрин-Интернэшнл ХХК-ийн дэд захирал **Б.Даваасүрэн:**

- Байнгын ашиглалтад оруулах саналтай.


Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**

- БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт бичих;
- Барилгын тухай хуулийн дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх;
- Батлагдсан барилгын зургийн дагуу гадна тохижилтыг бүрэн дуусгах, барилгын түр хашааг буулгах, гадна аюулгүй байдлыг хангуулах
- В1 дулаан зогсоол руу орох гарах хэсэгт саравч хийж гүйцэтгэх
- Өөрчлөлтийн зургийг батлуулж хянуулах хүчин чадал тодорхойлж албан тоот ирүүлэх /зохиогч, захиалагч/

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянгол дүүргийн 29 дүгээр хороо, Эрин интернэшнл ХХК-ийн захиалгатай, зоорьтой 2 давхар 2 блок, 12 (арван хоёр) автомашины дулаан зогсоолтой үйлчилгээний барилга, зоорьтой 16 давхар 1 блок, 18 (арван найм) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 112 (нэг зуун арван хоёр) айлын орон сууцны зориулалттай нийт 3 блок барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах ашиглалтад оруулах.

Комиссын дарга:  
Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч



..... (А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:  
Эрин Интернэшнл ХХК-ийн дэд захирал



..... (Б.Даваасүрэн)